“БОЛОР ЗООС” ББСБ-ЫН
УДИРДЛАГА-д

“ЦЭСБ-АУДИТ” ХХК
Нягтлан бодох бүртгэл, хяналтын
итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага

4256743, Дархан Уул аймаг, Дархан сум, 10-р баг
5-р хороо. “ЛХА” ХХК-ий 2 давхар 65 тоот
Утас/факс: 95112689, 89275858
Э-шуудан: tsesb.audit@gmail.com

2025-02-13 № 2/004
танай_____-ны №_____-т

Хараат бус аудиторын
Тайлан

Бид “Болор зоос” ББСБ-ийн 2024 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөрх тайлан тэнцэл, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр тус компанийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн,мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, зөв бодитой үзүүлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудыг дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд багтсан хэдий ч санхүүгийн тайлан ба аудиторын тайланд багтаагүй мэдээллээс бүрдэнэ. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй тул бид бусад мэдээлэлд баталгаажуулалт гаргахгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл аудитын явцад бидний олж авсан ойлголттой нийцэж байгаа эсэх эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм. Дээр дурьдсан горимуудыг гүйцэтгэх явцад энэхүү бусад мэдээлэлтэй холбоотой материаллаг буруу илэрхийлэл илрүүлсэн бол бид тайлагнах шаардлагатай байдаг. Үүнтэй холбоотой тайлагнах аливаа зүйлс байхгүй.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор компанийн удирдлагын хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, толилуулах нь Компанийн удирдлагын хариуцлага байна. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудиторуудын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гарган, өөр аливаа нэг этгээдэд биш Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох та бүхэнд тайлагнах нь бидний хариуцлага юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олс авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшиний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

ЗАХИРАЛ Ч.ЦЭРЭННАДМИД

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЦЭСБ-АУДИТ
ХХК
ТТО3052 ш.4256743

"БОЛОР ЗООС" ББСБ" АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөг/

Үзүүлэлт	1/1/2024	12/31/2024
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	35,131,785.24	47,737,250.01
Зээл	966,577,191.93	1,152,414,352.63
Факторингийн тооцооны авлага		
Хөрөнгө оруулалт		
Бусад санхүүгийн хөрөнгө	95,838,920.81	83,403,677.73
Санхүүгийн хөрөнгийн дүн	**1,097,547,897.98**	**1,283,555,280.37**
Татвар НДШ-ийн авлага		
Үндсэн хөрөнгө	105,805,461.47	86,050,713.77
Биет бус хөрөнгө		
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	**105,805,461.47**	**86,050,713.77**
НИЙТ ХӨРӨНГӨ	**1,203,353,359.45**	**1,369,605,994.14**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр		
Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	313,333,333.35	577,893,759.83
Үүсмэл санхүүгийн өр төлбөр		
Санхүүгийн өр төлбөрийн дүн	**313,333,333.35**	**577,893,759.83**
Татвар, НДШ-ийн өр төлбөр	16,235,163.39	7,253,830.58
Нөөц /Болзошгүй өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр төлбөр		
Бусад санхүүгийн өр төлбөр	504,000.00	277,000.00
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	**16,739,163.39**	**7,530,830.58**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	**330,072,496.74**	**585,424,590.41**
Өмч/ өөрийн хөрөнгө/		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	660,000,000.00	660,000,000.00
Өмчийн бусад хэсэг	1,960,000.00	1,960,000.00
Тусгай зориулалтын сан		
Хуримтлагдсан орлого, алдагдал	211,320,862.71	122,221,403.73
Нийт өмчийн дүн	**873,280,862.71**	**784,181,403.73**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	**1,203,353,359.45**	**1,369,605,994.14**

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР МНБ /Т.ЭРДЭНЭТУЯА/

"БОЛОР ЗООС" ББСБ" АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

/2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөг/

Үзүүлэлт	Тодруулга	1/1/2024	12/31/2024
Банканд байршуулсан хөрөнгийн			2,033,827.32
Зээлийн		440,708,399.89	314,250,005.17
Бусад		2,445.33	
Хүүгийн орлогын буцаалт		(26,538,021.11)	(8,663,516.06)
Хүүгийн орлогын цэвэр дүн		**414,172,824.11**	**307,620,316.43**
Хадгаламжийн хүүгийн зардал		108,349,439.33	57,351,245.11
Хүүгийн зардалын дүн		**108,349,439.33**	**57,351,245.11**
Хүүгийн цэвэр орлого		**305,823,384.78**	**250,269,071.32**
Эрсдлийн сангийн зардал		19,611,583.77	12,581,728.19
Эрсдлийн сангийн дараах цэвэр орлого		286,211,801.01	237,687,343.13
Бусад орлого		**145,808,682.23**	**79,243,735.58**
Хүүгийн бус орлого		84,730,716.04	36,139,324.83
Бусад орлого олз		61,077,966.19	43,104,410.75
Бусад зардал		**198,803,709.72**	**183,093,102.51**
Хүүгийн бус зардал		196,970,284.72	181,274,284.51
Бусад зардал, гарз		1,833,425.00	1,818,818.00
Татварын өмнөх орлого. Алдагдал		**233,216,773.52**	**133,837,976.20**
Орлогын албан татварын зардал		21,985,910.81	11,616,572.47
Тайлант жилийн татварын дараах ашиг		**211,230,862.71**	**122,221,403.73**

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР МНБ /Т.ЭРДЭНЭТУЯА/

"БОЛОР ЗООС" ББСБ" АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөг/

Үзүүлэлт	Гишүүний оруулсан хувь хөрөнгө	Өмчийн бусад хэсэг	Тусгай зориулалтын сан	Хуримтлагдсан орлого . Алдагдал	Нийт дүн
Залруулсан үлдэгдэл	**660,000,000**	**1,960,000**	**-**	211,320,862.71	**873,280,862.71**
Тайлант үеийн цэвэр ашиг алд					-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Дахин үнэлгээний нэмэгдэл					-
Өмчид гарсан өөрчлөлт					-
Хувиарласан ногдох хувь хөрөнгө					-
2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	**660,000,000.00**	**1,960,000.00**	**-**	**211,320,862.71**	**873,280,862.71**
Бүртгэлийн бодлогы өөрчлөлт					-
Залруулсан үлдэгдэл	**660,000,000.00**	**1,960,000**	**-**	**211,320,862.71**	**873,280,862.71**
Тайлангийн үеийн цэвэр орлого/алдагдал/				122,221,403.73	122,221,403.73
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт				(211,320,862.71)	(211,320,862.71)
Хувиарласан ногдох хувь хөрөнгө					-
Дахин үнэлгээний нэмэгдэл					-
2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	**660,000,000**	**1,960,000**	**-**	**122,221,403.73**	**784,181,403.73**
	-	-	-	-	-

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР МНБ /Т.ЭРДЭНЭТУЯА/

"БОЛОР ЗООС" ББСБ" АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

/2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөг/

Үзүүлэлт	Тодруулга	1/1/2024	12/31/2024
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн			
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан		414,170,378.78	1,534,983,623.29
Итгэлцлийн үйлчилгээнээс авсан			
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан			
Бусад		118,924,463.22	34,415,691.66
Үндсэн үйл ажиллагааний мөнгөн орлого		**533,094,842.00**	**1,569,399,314.95**
Олгосон зээл		108,349,439.33	1,143,061,000.00
Ажиллагсад олгосон		101,516,438.32	97,764,418.94
Татвар нийгмийн даатгалын байгууллагт төлсөн		14,351,248.92	63,442,690.40
Ашиглалтын зардалд төлсөн		21,659,339.17	129,325,143.50
Хангамжийн зүйл худалдан авахад төлсөн			
Бусад		150,640,122.36	80,600,813.25
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага		**396,516,588.10**	**1,514,194,066.09**
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		**136,578,253.90**	**55,205,248.86**
Банк санхүүгийн байгууллага төсөл хөтөлбөрийн зээлээс хү			990,000,000.00
Бусад			21,739,906.07
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн			**1,011,739,906.07**
Банк санхүүгийн байгууллага төсөл хөтөлбөрийн зээлд төлсөн			782,790,818.63
Төсөл ногдол ашиг		161,631,493.24	211,320,862.71
Бусад		1,833,425.00	60,228,008.82
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний зарла		**(163,464,918.24)**	**(1,054,339,690.16)**
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний			
Торгуулийн зардал			
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		**(26,886,664.34)**	**12,605,464.77**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ		62,018,449.58	**35,131,785.24**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		**35,131,785.24**	**47,737,250.01**
		-	**(0.00)**

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР МНБ /Т.ЭРДЭНЭТУЯА/